

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ НИСЭХ БУУДАЛ -ЫН**

**(ТӨСЛИЙН БАЙРШИЛ,НЭР)**

**2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**РЕГИСТРИЙН ДУГААР 2628546**

Боловсруулсан: Говь-Алтай аймгийн Нисэх буудлын

ТС-1 шатахууны лаборант нярав

Ч.Нямлхагва

2023 он

## 1. Төслийн танилцуулга.

Нэг. Ерөнхий мэдээлэл		
1.1	Төслийн нэр	"Алтай" нисэх буудал
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг	Монгол Улс, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг
1.3	Утас, Факс	Утас: , Факс: 70484044
1.4	Цахим хаяг	Govi-Altai.airport@mcaa.gov.mn
Хоёр. Төслийн талаарх мэдээлэл		
2.1	Төслийн байрлал	Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын төвөөс 5,8 км зайд байрлана. N48°51'21", E103°28'30" Аэродромын өндөр 1315м
2.2	Газар эзэмших гэрчилгээ	Есөнбулаг сумын Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 31- ны өдрийн газар эзэмших эрхийн 00000504,000000505 тоот дугаартай гэрчилгээ бүхий 145,697 га газрыг онгоц хөөрч буух зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшинэ.
2.3	Төслийн хүчин чадал	"Алтай" нисэх буудал нь ЗС ангиллын аэродром, цагт 100 хүн хүлээн авах терминал, аэродромын элементүүдийг хамгаалсан 8250 м урт хашаа, 50 автомашин зогсох бололцоотой автозогсоол, халаалтын зуух, цахилгаан хангамж,дэд өртөө, автограж, цэвэр усны худаг, бохирын цооног, антенны талбай, сүүдрэвч, шатахууны агуулах нь 2013 онд ашиглалатанд орсон 100 тонны ган, ил хэвтээ, конусан савтай. ТС-1 шатахууныг хадгалах зориулалттай, зэрэг барилга байгууламжтай.

### Нийгэм, эдийн засаг:

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум нь анх Говь-Алтай аймаг байгуулагдсан цагаас эхлэн хотын суурь тавигдаж 1942 онд 127 өрх 374 иргэнтэйгээр Есөнбулаг хот байгуулагдсан түүхтэй.Хуучнаар Засагт хан аймгийн Засагт ханы хошуу байжээ. Одоо Баяншанд, Баянхайрхан, Харзат, Жаргалант, Индэрт, Жинст, Оргил, Түмэн гэсэн төвийн 8 баг, Рашаант, Наран гэсэн хөдөөгийн 2 багийн нийт 5259 өрхөд 18749 хүн амьдардаг. Үүнээс Алтай хотод 4903 өрхийн 17460 хүн ам төвлөрөн суудаг. Хүн амын тоо болон нягтаршлаараа Говь-Алтай аймагтаа хамгийн өндөр бөгөөд үйлдвэрлэл үйлчилгээ хөгжсөн, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч олонтой сум юм. Далайн түвшнээс дээш 1550-2280 м өндөрт өргөгдсөн. Газрын гадаргын төрх байдал нь жигд бус, баруун талаараа Хантайширын нуруу, хойд талаараа Далангийн нуруугаар хүрээлэгдсэн,зүүн талаараа аараг толгодтой.Сумын нутаг дэвсгэрийн 20 хувь нь хангай, 50 хувь нь говь, 30 хувь нь тал хээрийн бүс эзэлдэг. Газар тариалан, мал аж ахуй хөгжүүлэхэд тохиромжтой.

**Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга  
хэмжээнүүдийн хураангуй:**

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо **магадлан жагсаах** аргыг ашиглаж, үр дүнг байгаль орчин, нийгмийн бүрдэл хэсэг бүрээр үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, эрчим, үр дагавар зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх байдлыг үзүүлдэг.

<b>Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд</b>	<b>Сөрөг нөлөө үүсч болзошгүй нөхцөлүүд</b>
Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх	Байхгүй
Бусад иргэн, ААН үйл ажиллагаагаа явуулдаг эсэх	
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрлөлтөд эмзэг, эсэх	Цаг уурын өөрлөлтөд эмзэг, тухайлбал: Орон нутагт хүчтэй салхи шуурга болох магадлал элбэг, шуурга болсон тохиолдолд нөлөөлийн эрчим дунд зэрэг -Үер, усны болзошгүй эрсдэл бага -Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөлөл бага.
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөж байгаа эсэх	Байхгүй
Болзошгүй хураамтлагдах нөлөөлөл үүсэх эсэх	Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх хуримтлагдах тээврийн хэрэгслийн утаа тоосжилт, ажлын байрны агаарын бохирдол тус тус хамаарна.

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаварын үнэлгээ			
		Бага	Дунд	Их	Аюултай
1	Барилга байгууламжуудаар газрын гадарга нөлөөлөлд өртөх байдал	х			
2	Хатуу хог хаягдал хөрсөнд алдагдаж, газрын гадарга бохирдож болзошгүй		х		
3	Шингэн хог хаягдал хөрсөнд алдагдаж, газрын гадарга бохирдож болзошгүй		Х		
	Нийт	1	2		

Дүгнэлт: Нийт нөлөөллийн 70% нь дунд, 30 нь бага ангилалд багтаж байгааг үндэслэж тухайн төсөл орчны газарзүй, ландшафт, геологи орчинд газрын хэвлий, газрын гадаргад дунд зэргийн эрчимтэй нөлөөлөл үзүүлэхээр байна гэж үзэв.

**2. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зорилт хамрах хүрээ**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино

## ГОВЬ-АЛТАЙ НИСЭХ БУУДЛЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн өртөг (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4		6	7	8	9
<b>Дуу чимээ</b>								
	Онгоц хөөрөх, буух үеийн дуу чимээ орчны шуугианы түвшнийг нэмэгдүүлнэ	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Агаарын хөлөгт ойр ажилладаг ажилчид		30	5 хүн х 30,0=150.0	2023	MNS ISO 226:2003 дуу чимээ – хэвийн норм- түвшний хэмжээ MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
<b>Хөрс, ургамлын бүрхэвч</b>								
1	Бохир ус, хатуу хог хаягдлыг цуглуулах, зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс орчны хөрс бохирдох нөхцөлтэй;	Хаягдал бохир ус, угаалгын бодисоор хөрс бохирдож болзошгүй тул хөрсөнд E-coli, Salmonella илрүүлэх шинжилгээ хийлгэх, хянаж байх	Уурын зуух Нисэх буудал		20	40,0	Жилд 1 удаа	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008
2	Ажиллагсдын хайнга үйл ажиллагааны улмаас орчны хөрсөнд бохирдол үүсэх Ахуйн гаралтай хатуу, шингэн хаягдлаар хөрс бохирдох.	Шатахууны агуулах орчмын хөрс, усанд хүнд металлын шинжилгээ хийлгэх	Шатахууны агуулах		40	40	2023	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3		ШТМ хөрсөнд алдагдсан үед хусаж авах, саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах,					Тухай бүр	

		шаардлагатай багаж материалыг байнга бэлэн байлгах	Шатахууны агуулах					
--	--	--	-------------------	--	--	--	--	--

<b>Усны нөөц ,чанар</b>								
1	Унд ахуйн зориулалтаар ус хэрэглэх тул усны нөөц хомсдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Хаягдал бохир ус стандартад заасан хэмжээнээс давах, улмаар сөрөг нөлөөлөл үзүүлэх Хатуу хог хаягдлыг цуглуулах,цэвэрлэх,зайлуулах үйл ажиллагаа зохих журмын дагуу хийгдээгүйгээс газрын доорх ус бохирдох	Унд ахуйн хэрэглээний усанд тогтмол хяналт тавьж байх	Нисэх буудал	12	5,0	60,0		Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Усны тухай хууль - MNS 6148:2010. Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ,
<b>Тав: Амьтны аймаг</b>								
1		Амьтан, мал нисэх зурвас, нислэгийн талбай руу орж дайруулж, гэмтэхээс сэргийлж тус нисэх буудлын хамгаалалтын хашааг жил бүр тордон засаж, сэлбэж байх	Нисэх буудал, аэродром		200.00	200.00	2023 он	
2		Шувуу, ан амьтаныг агаарын хөлөгтэй мөргөлдөх эрсдээс урьдчилан сэргийлж	Нисэх буудал, аэродром			2000.0	2023 он	Тухайн нислэг бүрт

**2. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө**

	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хугацаа	Зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх Технологийн хоцрогдол	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах				Өдөр бүр, тогтмол ажил эхлэхээс өмнө	- Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1, - MNS4995:2000. ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага - MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” - MNS ILO OSH1:2003. ХААЭА-н удирдлын тогтолцооны талаарх удирдамж - MNS ILO OSH0:2003. ХААЭА. Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS5002:2000. ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS5390:2004. ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага - MNS ISO13688:2000. ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага - Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль - MNS 4996 : 2000. “Ажлын байрны гэрэлтүүлгийн норм”
		Ажиллагсадыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Нисэх буудлын хүрээнд	2023 он	30*87=2,610	Жилд 1 удаа	
		Гал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт	бүх ажилчдад	700.0	жилд 2 удаа		
		Ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт	бүх ажилчдад				
		Байгаль орчинг хамгаалах сургалт					
Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	бүх ажилчдад						
2	Цаг агаарын гэнэтийн осол, эрсдэл үүсэх	Цаг уурын урьдчилсан мэдээллийг тогтмол авч, үйл ажиллагаатайгаа уялдуулах	Нисэх буудал			2023 он	
3	Шатах тослох материалыг их хэмжээгээр алдсанаас байгаль орчин болон хүний эрүүл мэндэд ноцтой хохирол, эрсдэл учруулах	Шатах тослох материалыг хадгалах сав, тээвэрлэх тээврийн хэрэгсэл, улмаар ажилтан албан хаагчдын мэдлэг чадварт тогтмол шалгалт, хяналт тавих	Үйл ажиллагааны бүхий л хүрээнд			2023 он	
4	Аюул ослоос урьдчилан сэргийлэх, ослын үед авах арга хэмжээнүүдийн талаар мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сургалт зохион байгуулах		Үйл ажиллагааны хүрээнд			2023 он	
	Нийт дүн				3,310.0		

3.Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдалын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сараг нөлөөлийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хог хаягдал, Халаалтын зуухнаас гарах хог хаягдал	Халаалтын зуухны үнс, нисэх буудлын ахуйн хог хаягдлыг эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулж сар бүр тогтмол ачуулж байх /Алтай хотын тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулан хамтарч ажиллах/			120	12	1440	Хог хаягдал тээвэрлэж зайлуулж байх / сард 1 удаа/	
2	Үйлдвэрийн	-							
3	Аюултай	Хөрсөнд хүнд металл, хортой бодисын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү илэрвэл саармагжуулах арга хэмжээ авах, бохирдсон хөрсийг хуулж авах зэрэг арга хэмжээ авах - ШТМ хөрсөнд алдагдсан үед хусаж авах, шаардлагатай багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах, Хатуу хог хаягдлыг тогтмол тээвэрлэж, хогийн нэгдсэн цэгт хаях, хогийн савыг цэвэрлэж, ариутгаж байх	Шатахууны агуулах				800	Тухай бүр	
4		Хаягдал бохир усыг сар бүр тогтмол соруулж цэвэрлэж байх /Ундарга Алтай ОНӨААТҮГ-тай гэрээ хийж хамтарч ажиллах/			40	12	480		
	Нийт						2720.0		

